



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2018 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/139

Булган

Гэрээ шууд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Булган сумын үерийн сувгийн даланг шинэчлэн засварлах ажлын гүйцэтгэгчээр сонгогдсон Улаанбаатар хотын “Баян өндөр булаг” ХХК-тай 76 200 000 /далан зургаан сая хоёр зуун мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/-д олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Гэрээний хугацаанд дээрх ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Баян өндөр булаг” ХХК /Л.Батноров/-д даалгасугай.

4. Гэрээнд заасан ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ